



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/308

Арвайхээр

**Үнэлгээний хорооны даргын үүрэгт ажлаас  
чөлөөлж, нөхөн томилгох тухай**


Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Спорт заалны барилга (Өвөрхангай Зүүнбаян-Улаан сум) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дарга Н.Ганболд нь тус тендерт оролцогч Смарт зоос ХХК-тай ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл үүссэн тул тус үнэлгээний хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Спорт заалны барилга (Өвөрхангай Зүүнбаян-Улаан сум) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Баясгаланг нөхөн томилсугай.

3. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Г.Баясгалан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н. ГАНБОЛД

011100863